



Эцсийн тайлан

“Олон суваг дамжуулах үйлчилгээ, телевиз хоорондын холболтын зохицуулалт, орлого хуваах зарчим, гэрээний нөхцлийн талаар олон улсын туршлага, зарчим судлах” сэдэвт судалгаа

2024.09.16

Агуулга

1. Судалгааны ажлын тухай	3
2. Дотоодын ТВ-үүдийн байр суурь	6
3. Олон улсын кэйс судалгаа	10
Индонез	10
Самоа	11
Фижи	11
Бутан	12
Лаос	12
Пакистан	13
Непал	13
Энэтхэг	13
Universal Services Directive	14
Их Британи	15
Мальта	16
Америкийн Нэгдсэн Улс	17
4. Тохиромжтой туршлага	20
5. Дүгнэлт ба санал	23
6. Эх сурвалжууд	29
i. Хавсралт: Асуумжийн үр дүн (нэгтгэл)	30
ii. Хавсралт: Асуумжийн үр дүн (задаргаа)	36

1. Судалгааны ажлын тухай

Судалгааны үндэслэл

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ), телевиз хоорондын холболт, дамжууллын асуудлыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон тэдгээр хуулиудад заасан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”, “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам” болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагуудаар зохицуулахаар заасан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хүрээнд бий болсон телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн ялгаа (өргөн нэвтрүүлгийн телевиз, арилжааны телевиз)-тай байдал нь ОСДҮЭ, телевиз хооронд гэрээ байгуулах явцад гомдол, маргаан дагуулж хууль, журмын дагуу гэрээг шинэчлэн байгуулахад хүндрэлтэй асуудлуудтай тулгараад байна.

Гэвч ОСДҮЭ талаас болон тухайн телевизийн хөтөлбөрөөс шалтгаалан тусад нь гэрээ байгуулахгүй байх асуудал үүсдэг. Мөн хөтөлбөр дамжуулах гэрээний зарчмыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3 (өргөн нэвтрүүлгийн радио, телевизүүд нь энэ хуулийн 6.1.2-т заасан үйлчилгээний үндсэн багцын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний орлогын 15 хувиас доошгүй хэмжээгээр өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс авах;), 20.5.4 (бусад арилжааны радио, телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь харилцан тохиролцох.) -т өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн авах хөлсийг тодорхой заасан бол арилжааны телевизүүдийн тухайд арилжааны зарчмаар харилцан тохиролцох гэж заасан байдаг.

Иймд олон улсад энэхүү асуудлыг хэрхэн зохицуулж буй туршлага, зарчмын талаар судалж, ОСДҮЭ, телевиз хоорондын гэрээний төрөл, үйл ажиллагааны онцлогийг харгалзан цаашдын зохицуулалтын оролцооны байдлыг тодорхойлох, одоогийн зохицуулж буй хууль, журам, нөхцөл шаардлагуудад өөрчлөлт оруулах санал боловсруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Судалгааны аргачлал

Судалгааны мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж тайлан, саналыг боловсруулсан. Судалгааны мэдээллийг цуглуулахад дараах аргачлалыг ашигласан.

- *Хоёрдогч мэдээлэл (Desktop research):* Европын орнуудын болон АНУ-ын туршлагыг хоёрдогч мэдээлэл дээр үндэслэн цуглуулсан. Их Британий хувьд хоёрдогч мэдээллээс гадна гүнзгийрүүлсэн ярилцлагын арга ашигласан.
- *Анхдагч мэдээлэл (Асуумж):* Мэдээлэл цуглуулах зорилгоор асуумж бэлтгэж, судалгаанд оролцогчдод хандсан боловч улс орнуудын зах зээлийн оролцогчдын нөхцөл байдал, нэр томъёо, судалгаанд

оролцогчдын туршлага зэргээс хамаарч асуумжийн үр дүнг судалгаа, мэдээлэлд ашиглах шаардлагагүй гэж үзсэн. Иймээс асуумж нь гүнзгийрүүлсэн ярилцлага хийх удирдамж маягаар ашиглагдсан.

- *Гүнзгийрүүлсэн ярилцлага (Дотоод):* Дотоодын зах зээлийн оролцогчидтой гүнзгийрүүлсэн ярилцлага хийж, тулгамдаад буй асуудлуудыг илрүүлсэн. Дотоодын зах зээлийн оролцогчдоос харьцангуй зөв сонголт хийсэн нь тэдний санал хэт нэг талыг бариагүй, бодлоготой байснаас ажиглагдана.
- *Гүнзгийрүүлсэн ярилцлага (Гадаад):* Гадны туршлага, тэр тусмаа Ази-Номхон далайн орнуудын туршлагыг гүнзгийрүүлсэн ярилцлага аргаар судалсан. Судалгааны хувьд зорилгоо биелүүлсэн боловч хэд хэдэн хүндрэл байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.
 - Зах зээлийн ерөнхий нөхцлийг бүгдийг нь мэддэг эх сурвалж, судалгаанд оролцогч олоход хүндрэлтэй байлаа. Ялангуяа томоохон улсуудын хувьд маш олон кэйс байдаг, тэр бүхнийг нэг хүн мэддэг байх боломж тун хомс байна. Жижиг орнуудын хувьд харьцангуй боломжтой байлаа.
 - Манай судалж буй асуудлын тухайд тухайн орны нөхцөл байдал нь харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөн түүх, зах зээл, технологийн хөгжил, хүн амын болон газар зүйн онцлог зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай байдаг ажээ. Өөрөөр хэлбэл яг ижил хоёр кэйс олно гэдэг үндсэндээ боломжгүй зүйл байна.
 - Ази-Номхон далайн орнуудын төлөөлөлтэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийхэд мэдээлэл сайтай судалгаанд оролцогч олдсон ч хэлний бэрхшээл зохих ёсоор үүсэж байлаа.

Судалгааны асуудал

Судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлага, мөн дотоодын ТВ-үүдийн байр суурь, хоёрдогч мэдээлэл дээр шинжилгээ хийж үзээд дараах асуудлууд дээрх улс орнуудын байр суурийг тодорхой болгох нь том утгаараа манай судалгааны зорилгыг биелүүлж, бидэнд үйлдэлд хөтлөхүйц хэрэгтэй мэдээлэл гаргаж өгнө гэж үзсэн.

Must-carry концепт: Улс орнууд must-carry гэдэг статусыг тодорхойлохдоо юун дээр үндэслэж байгаа. Энэ ялгаа зааг тодорхой байх нь одоо манайд үүсээд байгаа өргөн нэвтрүүлгийн болон арилжааны гэсэн хоёр лицензийн асуудлыг тодорхой болгох боломж олгоно.

Must-carry ба хөтөлбөр дамжуулах төлбөр: Дээрхтэй уялдуулаад хэрвээ must-carry статустай тохиолдолд тэр нь ОСДҮЭ-тэй тогтоох бизнес харилцаанд ямар давуу болон сул тал үүсгэж байгаа вэ гэдэг нь чухал.

Non-must-carry ба хөтөлбөр дамжуулах төлбөр: Мөн дээрхтэй уялдуулаад хэрвээ заавал дамжуулах статусгүй тохиолдолд ОСДҮЭ-тэй ямар харилцаа үүсэж байгаа вэ гэдгийг нь олж мэдэх нь чухал байв. Үүний хүрээнд агаарын давтамж

ашигладаггүй, зөвхөн кабелийн сувгуудаар гардаг суваг байдаг эсэхийг лавлах шаардлагатай байлаа.

Техник холболтын нөхцөл ба төлбөр: Дээрх тодорхойлолт, зохицуулалтууд нь телевиз болон ОСДҮЭ-ийн хоорондын техник холболт, түүний нөхцөлд ямар нөлөө үзүүлж байгааг судална.

Асуумж болон гүнзгийрүүлсэн ярилцлагыг эдгээр асуудлын хүрээнд бэлтгэн явуулсан.

2. Дотоодын ТВ-үүдийн байр суурь

Энэхүү судалгааны хүрээнд Монгол дахь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс санал, хүсэлт авч албан уулзалтууд зохион байгуулж, судалгаандаа тусгав. Өргөн нэвтрүүлгийн телевизүүд олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээнд сувагчлалаа холбож хөтөлбөрөө дамжуулах асуудалд дараах санал асуудлууд гарав. Үүнд:

- Өргөн нэвтрүүлгийн байгууллагууд, ОСДҮЭрхлэгчид оюуны өмчийг дээдэлж, албан ёсны зөвшөөрөлтэй бүтээл, нэвтрүүлэг нэвтрүүлэх, албан ёсны зөвшөөрөлтэй сувгуудыг дамжуулдаг байх нь энэ салбарт шударга өрсөлдөөнийг дэмжин хамгаалах, эрх тэгш байдлыг дэмжихэд чухал хүчин зүйл тул зайлшгүй анхаарах.
- Эдгээртэй холбоотой хууль, дүрэм журмуудыг эргэн харах ялангуяа хэрэгжилтийг хангуулахад Монгол Улсын Их Хурлаас “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль”-д нарийвчлан тусгаж өгөх.
- Монголын Телевизүүдийн Холбоонд харъяалагддаг тодорхой хэдэн телевизүүд нь “Өргөн нэвтрүүлгийн хууль”-аар санхүүжилт авдаг боловч, арилжааны телевизүүд нь ижил үйлчилгээний үүрэг хүлээсэн ч хамаарагдахгүй байна.
- Монголын Телевизүүдийн Холбооны үйл ажиллагаанд холбогдох эрх бүхий байгууллагууд нарийн хяналт тавих шаардлагатай.
- Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч нь үзэгчдэд илүү чанартай, бүтээл, хөтөлбөрийг бүтээж, илүү олон хүн цалинжуулж, техникийн стандартын шаардлагыг хангаж холбогдох дүрэм журмыг сайн мөрдөж ажилласан хэдий ч өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээрүү шилжих ямар ч боломжгүй байдаг. Үүнд ХХЗХ хяналт тавьж өргөн нэвтрүүлгийн үйлчилгээрүү шилжих боломжийг олгодог зохицуулалт байдаггүй нь энэ салбарын хөгжил болоод өрсөлдөөнийг тодорхой хэдхэн телевизээр хязгаарлаж байна.
- Холболт болоод дамжуулалтын зардалд их хэмжээний мөнгө төлдөг. ХХЗХ зааглах цэгийн асуудалд зохицуулалт хийж өгөх ёстой. Тохиролцоо хийх ямар ч боломжгүйгээр ОСДҮЭ эрхэлж байгаа байгууллагууд нь заавал энэ шилэн кабелиар дамжуулж холбогд, бидэнд төлбөр төл гэдэг шаардлага тавьж байгаа нь телевизүүдэд хүндрэл учруулж байна. Тухайн ОСДҮЭ-ийн зааглах цэг дээр телевизийн сигналаа аваачих нь манай телевизийн үүрэг, бид өөрсдөө мэдэх байтал ямар шилэн кабелиар аваачыг хүчээр тулгах хэлбэрээр зааж өөрсдөө шийдэх боломжыг олгохгүй байгаа нь монополи байдлыг үүсгэж байна.
- Зааглах цэгээс хоёр тийшээ буюу ХХЗХ- ний харилцан холболтын журмын дагуу дата төв байгаа цэгээс хоёр тийшээ байрлаж байна гэсэн үг. Эндээс зааглах цэгийнхээ дагуу хоёр тийшээ хариуцаж байгаа мэт харагдаж байгаа боловч арилжааны телевиз нь өөрийн байрнаас ОСДҮЭ-ийн headend байгаа цэг хүртэл хариуцаж техник холболтын зардлыг

гаргаж байна. Энэ төлбөр дээрээ арилжааны телевизүүд нь ОСДҮЭ-тэй тохиролцох хэрэгтэй болдог. Харилцан холболтын төлбөр төлөхгүй, зөвхөн шилэн кабелийн түрээсээ төлье гэхэд үнэ өртөг нь өндөр хэвээрээ гардаг. Үнийн задаргаа хармаар байна гэхээр ОСДҮЭ тайлбарлаж чаддаггүй. Харилцан холболтын төлбөр гэдгийг шилэн кабелийн түрээсийн зардал гэх нэрээр солиод оруулж ирж байна. ОСДҮЭ-шилэн кабелийн холболтын цэг дээр нэг компанийг тулгадаг нь зардал ихсэхэд нөлөөлдөг.

- Дуу дүрсний дохионы чанарт ОСДҮЭ тус бүр өөр өөр түвшний шаардлага тавьдаг нь телевизийн эфирийн гаралтын түвшинд сөргөөр нөлөөлдөг.
- Орон нутгийн телевизүүд нь Юнивишн, ДДЭШ, Монгол сат зэрэг ОСДҮЭ-ийн сувгаар орон нутгийн телевизүүдийг үзэх хандалт сувгийн дарааллаас болж маш муу байдаг.
- Орон нутгийн телевизүүд орон нутгийнхаа иргэдийн мэдэх эрх, орон нутгийнхаа мэдээ, мэдээллийг авах эрхийг хангаж ажилладгийн хувьд тэдний онцлогийг холбогдох хууль тогтоомжид тодорхой тусгаж өгөх.
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжтай холбоотой асуудлаар үзэгчдээс маш их гомдол ирдэг ба энэ хураамжаас орон нутгийн телевизүүд ямар ч хувь хүртдэггүй. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамжийн хуулин дахь заалтаар МТХ-д гишүүнчлэлтэй телевизүүд МТХ-оор дамжуулан үзэгчдийн тоо хандалт зэргийг үндэслэн хуваарилна гэж заасан боловч өнөөдрийг хүртэл зөвхөн 18 телевиз л энэ хураамжийг хуваан авч байгаа нь хуулийн заалтыг ноцтой зөрчиж байгаа бөгөөд энэ асуудлаар хуулинд өөрчлөлт оруулах ажлын хэсэг ЦХХХЯ дээр 2022 оноос эхлэн байгуулагдсан боловч өнөөдрийг хүртэл ямар ч шийдэлд хүрээгүй байна. Орон нутгийн телевизүүд МТХ-той удаа дараалан уулзалт хийж зөвшилцсөний үндсэн дээр орон нутгийн телевизүүд холбоогоороо дамжуулан гишүүнчлэлтэй болсон боловч одоог хүртэл энэ хураамжаас хувь хүртэхгүй байгаа бөгөөд энэ тухайд МТХ-ны зүгээс ОСДҮЭ-д орон нутгийн үзэгчдийн тоог гаргаж өгдөггүй гэсэн тайлбар хийсээр бүтэн жилийн нүүр үзэж байна. Энэ хураамжтай холбоотой заалтыг хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шударга, тэгш байлгах агуулга болгон өөрчлөх саналыг гаргаж байв.
- *Орон нутагт өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн ЗААГЛАХ ЦЭГ нь тухайн орон нутагт байх ёстой хэдий ч ОСДҮЭ-д зөрчиж тус бүр өөрийн шилэн кабелийг телевиз болгон луу татан оруулсанаар холболттой холбоотой олон асуудлыг дагуулж байна. Тухайлбал холболтын төлбөр тооцооны өртөг өндөр байдаг нь зааглах цэгээр дамжуулан холбох бус Улаанбаатар хот дахь студи хүртэл дамжуулалтын урсгалын зардал нэрээр сар бүр 1 сая төгрөгнөөс дээш төлбөр нэхэмжилж байгаа нь орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд санхүүгийн хувьд маш хүнд нөхцөл байдал үүсгэдэг.*

Дээрхийг агуулга, учир шалтгааны хувьд эмхэтгэж үзвэл дараах хэдэн асуудал дээр зангидагдана.

1. Must-carry статус гэж байгаа юу? Тэр нь ямар учиртай вэ?

Өргөн нэвтрүүлгийн 18 суваг нь хуулиараа ОСДҮЭ-чид заавал дамжуулах шинжтэй байгаа. Энэ 18 яагаад must-carry болсон шалтгаан нь өргөн нэвтрүүлгийн лицензтэй буюу өөрөөр хэлбэл РТҮС-ний сүлжээгээр орон даяар гарч байгаа, агаарын давтамж ашиглаж байгаа учир олон нийтийн өмнө хүлээсэн үүрэгтэй гэдэг санаа үйлчилж байгаа юм шиг. Гэтэл нэг талаас РТҮС-ээр 18-уулаа бүрэн гарч чадахгүй байгааг судалгаанд оролцогчид дурдаж байна. Нөгөө талаас ӨНТХ батлагдахаас өмнө ОСДҮЭ-чид техник холболтын төлбөр гэж авдаггүй байсан бол ӨНТХ батлагдаж, ӨНТ-үүд хураамж авдаг болсноор техник холболтын төлбөрөө төлөхийг шаарддаг болсон нь яг одоогийн бидний Арилжааны ТВ-үүдтэй адилхан нөхцөлд хүргэж байгаа ажээ.

Гэтэл Арилжааны ТВ-үүд техник холболтын төлбөрөө л төлчихвөл ОСДҮЭ-ийн үндсэн багц буюу basic tier үйлчилгээнд багтдаг. Өөрөөр хэлбэл зарим орнуудад байдаг Pay TV гэдэг ангилалд хамаатуулж авч үзэхэд учир дутагдалтай болдог. Энэ нь ч контент худалдан авах зэрэг үйл ажиллагаанд тодорхойгүй байдлыг үүсгэдэг байна.

Эндээс харахад одоогийн ӨНТ, АТ гэсэн ангилал нь яагаад ч must-carry, non-must-carry гэсэн ялгааг тодорхойлох аргагүй, нэг бол аль ч must-carry биш, нөгөөтэйгүүр бүгд must-carry юм шиг нөхцлийг үүсгэж байна.

Энэ нь must-carry гэдэг ойлголт бусад улсад яг ямар үзэл санааны хүрээнд тодорхойлогдож байгааг судлах үндэслэл болно.

2. Яагаад заавал энэ 18 мөнгө авдаг вэ?

Агаарын давтамж буюу улсын өмчийг ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа гэдэг утгаараа ӨНТ-үүдийн контентийн агуулгад шаардлага тавигдаж ирсэн түүхтэй байна. Энэ нь олон нийтийн радио, телевиз үүссэн цаг үетэй зэрэгцэн хөгжиж ирсэн тул ӨНТ-үүдийг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө болон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг, төсвөөс санхүүжүүлдэггүй юм аа гэхэд дэд бүтцийн хувьд дэмжлэг үзүүлдэг загвар аль ч улсад оршин байна.

Монголын телевизийн зах зээл дээр ажиллаж байгаа ӨН, арилжааны болон орон нутгийн телевизүүд МТХ-ны хураамжийг хэрэглэгчээс авч байгаа тал дээр сөрөг байр суурь байхгүй. Гэхдээ энэ нь хэрэглэгчээс авч байгаа төлбөр үү, эсвэл ОСДҮЭ дээр ноогдуулж байгаа төлбөрийг ОСДҮЭ нь хэрэглэгчээс авч байгаа юм шиг харагдуулж байгаа юу гэдэг дээр тодорхой үзэл санааны хувьд нэгдээгүй байна.

Харин аль аль талуудын (ӨН, арилжааны болон орон нутгийн ТВ) сонирхож байгаа асуулт бол яагаад яг энэ 18 одоогийн байдлаар хамрагдаж байгаа вэ. 17 эсвэл 19 байж болох уу гэдэг асуудал сонирхолтой бөгөөд энэ асуудал төдий л тодорхой болж өгөхгүй байгаа нь шударга бус гэсэн ойлголтыг бий болгож байна. Нөгөө талаас МТХ хураамжийн орлогыг ТВ-үүдэд хуваарьлахдаа ТҮС-г

үндэслэнэ гэсэн нь өнөөг хүртэл хэрэгжээгүй байгаа нь мөн л асуудал дагуулж байгаа ажээ.

Иймээс дээр дурдсан must-carry асуудлыг хэн нь хэндээ мөнгө төлдөг вэ гэдэг талаас нь мөн лавшруулж судлах шаардлага үүсэж байна.

3. Зааглах цэгийн асуудал

Хэдийгээр одоогоор ХХЗХ-оос зааглах цэг гэдэг ойлголтоор ТВ болон ОСДҮЭ-ийн хоорондын техник холболтын асуудал дээр шийдэл, логик гаргаж өгсөн боловч тэр нь амьдрал дээр төдийлөн хэрэгжихгүй байна. Энэ нь явсаар контент, түгээлт хоёр нь аль нь хүчтэй байгаагийн асуудал болно. Өөрөөр хэлбэл одоогоор түгээлт тал нь илүү хүчтэй байгаа учир контент үйлдвэрлэгч тал өөрсдийн нөхцлөө тулган хүлээлгэх, тохиролцоо хийх боломжоор төдийлөн хомс байгаа ажээ. Гэхдээ жил ирэх тусам төлбөрийн хувьд хямдарч, арай бодит болж байгаа тухай судалгаанд оролцогчид ярьж байна. Зааглах цэг гэдэг нь бодитоор оршдог зүйл төдийлөн биш. Бодитоор оршдог байх эсэх нь эргэлзээтэй асуудал байна.

Иймээс ТВ болон ОСДҮЭ-ийн хоорондын техник холболтын хэлбэр, түүнтэй холбогдох зардлын санхүүжилтийн зарчмын асуудлыг судалгааны хүрээнд илрүүлэх шаардлагатай байна.

3. Олон улсын кэйс судалгаа

Ази, номхон далайн орнууд

Must-carry гэдэг ойлголт үндсэндээ төрийн телевиз гэдгээр тодорхойлогддог. Ер нь must-carry гэдэг зохицуулалт төдийлөн байдаггүй. Must-carry гэдэг зохицуулалт бол зах зээл талаасаа харьцангуй хөгжсөн улсад байгаа зохицуулалт болох нь анзаарагдаж байна.

Индонез

TVRI гэдэг ОНТ-ээс гадна 13 хувийн ТВ бродкастэр үйл ажиллагаа явуулдаг. Шугаман дамжуулалт DVB-T2 технологиор явж байна. 2022 оны 11 сарын 2-нд үндэсний хэмжээнд ASO (Analog switch off) болсон.

TVRI нь Үндэсний хэмжээнд 3 суваг (шугаман), бүс нутгийн хэмжээний 34 суваг (шугаман) цацаж байна.

ОСДҮЭ болон ТВ үйлчилгээ хүлээн авж буй байдлын хувьд 60% нь Terrestrial FTA DVB-T2, 10% нь Pay TV, 10% нь DTH FTA, 15% нь Аналог кабел, 5% нь OTT оператор гэсэн байна.

Индонез улс 17,000 аралтай. 83,218 тосгонтой (280 сая хүн, 73 сая өрх). Газарзүйн онцлог, хүн амын тоо, төвлөрөлөөсөө хамаараад физик кабел татдаг кабелийн оператор зах зээлд давамгайл байдалтай болоход бараг боломжгүй байна.

Must Carry гэдэг зохицуулалт албан ёсоор байхгүй боловч төв телевиз буюу TVRI болон 13 үндэсний хэмжээний бродкастэр нь de facto must carry болдог. Гэхдээ TVRI-ийг кабелийн сувгууд авч дамжуулахад үнэгүй бол судалгаанд оролцогчийн хэлснээр MNC-ийн мэдлийн сувгийг дамжуулахын тулд кабелийн операторууд мөнгө төлдөг, тэр нь цэвэр хоорондын гэрээгээр зохицуулагддаг байна.

MNC гэдэг нь 13 үндэсний хэмжээний сувгийг ажиллуулдаг 4 группын нэг. MNC нь үндэсний хэмжээний 4 суваг, Transcorp үндэсний хэмжээний 4 суваг, бусад сувгийг EMTech групп гэх мэт томоохон компаниуд эзэмшдэг. Үүнээс гадна MNC групп нь интернэт, IPTV үйлчилгээ, хиймэл дагуулын үзүүлдэг компани мөн эзэмшдэг бол, Transcorp-ийн хамааралтай компани интернэт, хиймэл дагуулын кабелийн үйлчилгээ эрхэлдэг.

Техник холболт ба зааглах цэгийн тухайд дээр дурдсанаар TVRI-аас гадна үндэсний хэмжээнд цацдаг 13 суваг байдаг бол орон нутгийн шинжтэй мянга, мянган телевиз ажилладаг. Үүнийхээ хэрээр мянга мянган кэйс байж таарах бөгөөд энэ бүхэн өөрсдийн тохиролцоогоор (private agreement) зохицуулагддаг, судалгаанд оролцогчийн мэдлэгийн хүрээнд бол төрөөс зохицуулсан зүйл байхгүй гэсэн.

Самоа

Самоа улс нь 202,000 орчим хүнтэй (Дархан+Эрдэнэт). Газар нутгийн хэмжээ нь 2,800 км.кв орчим (Говьсүмбэрийн хагас). Хоёр том арлыг тойрсон хэдэн жижиг арлууд дээр 300 гаруй тосгодоод амьдардаг. Өөрөөр хэлбэл Самоа нь жижигсгэсэн Улаанбаатар.

Судалгаанд оролцогчийн мэдээлснээр дотоодын 9 сувагтай гэсэн боловч мэдээллийг шалгахад 5-аас бусад сувгийн мэдээлэл олдоогүй. Юутай ч засгийн газрын ажиллуулдаг 1, сүмийн ажиллуулдаг 1 суваг бусад нь хувийн, арилжааны сувгууд байна. Өөрөөр хэлбэл дотоодын 3-6 арилжааны суваг байдаг.

Самоа улс нь арлуудаас тогтдог учир аналог кабелийн үйлчилгээ төдийлөн явцтай байгаагүй. Хиймэл дагуулын кабелийн үйлчилгээ хамгийн тохиромжтой байсан. Одоогоор ихэнх айл хиймэл дагуулын кабелиар эсвэл шууд FTA үйлчилгээ хүлээн авч үздэг. Нийт ОСДҮ хэрэглэгчийн дор хаяж 50% нь хиймэл дагуулын кабелийн үйлчилгээ авдаг. Тэрийг нь Digicel Samoa (ОУ компани, үүрэн телефоны үйлчилгээтэй) ажиллуулдаг.

Digicel Samoa сүлжээгээр гарахын тулд хувийн ТВ-үүд мөнгө төлдөг тухай судалгаанд оролцогч дурдсан. Хэр их мөнгө төлдөг нь хоорондын гэрээгээр тохиролцдог. Үүнийг зохицуулсан тодорхой зохицуулалтын талаар мэдэхгүй байна (3-6 телевиз л байгаа).

Сүүлийн үед гарч ирж буй IPTV болон OTT үйлчилгээ энэ давамгайл байдлыг аажмаар үгүй хийж байгааг хэлж байна.

Самаогийн төрийн телевизийг Харилцаа холбооны яам нь ажиллуулдаг, дамжуулах сүлжээг Дэд бүтцийн яам нь хариуцдаг.

Фижи

Фижи улс нь 900,000 орчим хүнтэй. 200,000 өрхтэй. Газар нутгийн хэмжээ нь 18,000 км.кв (Говьсүмбэр х3). Хоёр том арал, маш олон жижиг арлуудаас бүрддэг.

Дотоодын том 3 телевизийн сувагтай. Эхэндээ төрөөс нэгийг нь дэмждэг байж байгаад одоо бол 3-уулаа төсвөөс дэмжлэг авч байгаа.

Бараг 98% terrestrial сүлжээтэй. Иргэд түүгээрээ хүлээн авч үздэг. Кабелийн үйлчилгээ, хиймэл дагуулын кабелийн үйлчилгээнүүд байдаг ч тэр нь төдийлөн түгээмэл биш. Мөн үүрэн телефоны үйлчилгээ үзүүлдэг компаниуд, ТВ ажиллуулдаг компаниуд нь давхар ОСДҮЭ ажил хийдэг.

Ард иргэддээ ОСДҮ-г илүү үр дүнтэй хүргэх зорилгоор тус улсын засгийн газраас Walesi гэдэг үйлчилгээг нэвтрүүлсэн. Digital terrestrial broadcast system гэдэг технологиор ажилладаг. Айлууд set-top-box нэг удаа аваад л болдог. Хамгийн гол нь Walesi гэдэг апп байдаг (Play store дээр 500к+ таталттай байна). Ингээд Фижигийн бүх суваг Walesi-аар дамжих бөгөөд тэр нь үнэ төлбөргүй

байхаар зохицуулсан. Walesi-ийн өдөр тутмын үйл ажиллагааг төв телевизээ ажиллуулдаг Fijian Broadcasting Corporation хариуцдаг.

Бутан

Бутан улс 800,000 орчим хүн, 200,000 орчим өрхтэй. 900 тосгонтой. Газар нутгийн хэмжээ нь 38,394 км.кв (~Сэлэнгэ аймаг). Ерөнхийдөө уулан дунд амьдардаг.

Төв телевизээс өөр ТВ үндсэндээ байдаггүй. Уулархаг нутаг учир төв телевиз нь хуучин хиймэл дагуулаар дамжуулан дахин дамжуулах станцуудаар сүлжээгээ цацдаг байсан. Одоо тэр хиймэл дагуулын төлбөрөө хэмнэхийн тулд MSO гэдэг байгууллагатай хамтраад шууд газрын сувгаар шийдсэн.

MSO гэдэг нь Бутан 100+ кабелийн операторуудын нийлж байгуулсан зааглах цэг. Төв телевизийн мастер контролоос шууд шилэн кабелиар MSO (Multi-service operator) руу холбогддог. MSO-оосоо яаж авах нь кабелийн операторуудын өөрсдийн асуудал болсон. MSO нь одоо бол ашигтай ажиллаж байгаа, мөнгө хийж байгаа. Одоогоор төв телевиз, MSO хоёр хоорондоо ямар нэгэн төлбөр төлдөггүй. “Харин хувийн ТВ гараад ирвэл мөнгө нэхэх юм шиг байгаа юм” гэж байв.

Одоогоор өрхүүдийн 90% нь ямар нэг кабелийн үйлчилгээ авч байгаа, 10% нь DTH буюу хиймэл дагуулаар явж байгаа. Гэхдээ энэ DTH үйлчилгээнд зориулсан хиймэл дагуулын үйлчилгээг Энэтхэгээс үнэ төлбөргүй үзүүлдэг.

Лаос

Лаос улс 7.6 сая хүн, 1.6 сая өрхтэй. 10,000 гаран тосгонтой. 236,800 км.кв газар нутагтай (Монголын 1/6). Далайд гарцгүй. Энэ улсын зах зээлийн онцлог нь гэхдээ газарзүйн байршлаасаа илүү улс төрийн түүхтэй нь холбоотой.

Лаос улс одоо ч гэсэн коммунист улс гэж судалгаанд оролцогч тодорхойлж байна. Хувийн ТВ-үүд гэж байгаа. Гэхдээ цензур өндөртэй учраас дуу хөгжим, спорт, энтертайнмент чиглэлийг чухалчилдаг. Гол ТВ-үүд нь бүгдээрээ төрийн өмчтэй, төрийн хатуу хяналтанд үйл ажиллагаа явуулж байна.

ОСДҮЭ-ийн хувьд нөхцөл байдал мөн ижил. Үндсэн том үйлчилгээ эрхлэгчид нь төрийн өмчит. Ер нь медиа зах зээл, орон зайнд төрийн оролцоо маш өндөр. Телевиз болон ОСДҮЭ аль аль нь харилцаа холбооны яамны хяналтанд үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч нөхцөл байдлыг өөрчилсөн гол өөрчлөлт интернэт, 4G үйлчилгээ нэвтэрч эхэлснээр өрнөсөн. Одоогоор 95% гар утастай, 5G үйлчилгээ нэвтэрч байгаа. 2013 онд интернэт хэрэглээ нэмэгдэж, ухаалаг утас олноор барьж, сошиал медиа хөгжсөнөөр тэсрэлт болсон. Жинхэнэ private media тэр орон зай дээр л байдаг. Facebook, Youtube хэрэглээ маш их байгаа.

Пакистан

Пакистан 241 сая хүнтэй. 32 сая өрхтэй. 50,000 гаран тосгонд амьдардаг. Газар нутгийн хувьд 881,913 км.кв (Монголын 1/2). Цөмийн зэвсэгтэй, мусульман шашинтай улс.

100 гаруй дотоодын ТВ үйл ажиллагаа явуулдаг (142 хиймэл дагуулын ТВ лиценз хүчинтэй байгаа).

Монголд болж байсан нарийн ширийн асуудлууд энд ч болж байгаа нь ажиглагдсан. Судалгаанд оролцогчийн хэлснээр ОСДҮЭ нь томорч, хүчийг авсан. Иймээс улс төрийн нөлөө нь ТВ тал дээр нь орж чадахгүй бол ОСДҮЭ дээр ордог болсон. Жишээ нь, дургүй сувгийнхаа байршлыг өөрчлөөд бүр хойшоогоо тавьсан, бүр гарахыг нь болиулсан зэрэг тохиолдол бий ажээ.

Интернэт нэвтрэлт сайжирч, ОТТ үйлчилгээ нэвтэрснээр нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа. Гэхдээ л кабел операторууд нөлөөтэй хэвээр байна.

Зааглах цэгийн хувьд телевизүүд “provides receivers to the cable operators for the downlink of their transmission signal” хариуцдаг. Цаашаа яаж дамжуулахыг нь кабелийн операторууд өөрсдөө мэднэ. Бродкаст хийдэггүй, зөвхөн кабелийн оператороор гардаг ТВ гэж байдаг уу гэхэд байхгүй гэж хариулсан.

Непал

Непал 30 сая орчим хүн, 5.5 сая орчим өрхтэй. 36,000 тосгонд амьдарна. 147,516 км.кв газар нутагтай (Монголын 1/10).

Улс даяар цацагддаг 60 орчим ТВ байна. Өрхүүдийн хувьд ТВ хүлээж авах үндсэн хэрэгсэл нь ОСДҮЭ-ийн үйлчилгээ байна. DTH, DTV, MMDS, Cable, IPTV гэсэн лицензүүд олгогддог. IPTV технологи гарч ирснээр ISP-үүд кабелийн үйлчилгээ үзүүлэх болсон.

Непалд үндэсний, олон нийтийн бродкастэр 2 л байдаг. Бусад нь хувийн юм уу, community байна. Кабелийн операторууд нь бүгд хувийн бизнес байдаг. Олон нийтийн бродкастэр нь ОСДҮЭ-ээс мөнгө авдаггүй. Харин бусад ТВ-үүдэд кабелийн операторууд нь мөнгө өгч контентийг нь авдаг. Хэдийг төлдөг нь тэдгээрийн хоорондын хэлэлцээрээс хамаардаг.

Непал улсын хувьд ТВ үйл ажиллагаа эрхлэх лицензтэй байна гэдэг нь шууд must-carry гэсэн үг болно.

Энэтхэг

Асар их хүн амтай, маш том газар нутагтай улс. Монгол Улстай харьцуулахын аргагүй. Тэр хэрээрээ маш олон кэйс энд байна. Судалгаанд оролцогчийн хувьд Doordarshan TV-д сэтгүүл зүйн чиглэлээр ажилладаг хүн байв.

Кабелийн үйлчилгээ ер нь унаж байгаа, IPTV илүү сонирхолтой болж байгаа. Must-carry сувгийн хувьчд төрийн мэдлийн ТВ-үүд гэж шууд ойлгогддог. Төрийн мэдлийн ТВ-үүд заавал гарч байх ёстой. Интернэт нэвтрэхийн хэрээр ОТТ

үйлчилгээ газар авч, одоогоор Netflix гэх мэт гадны, Zee гэх мэт дотоодын OTT үйлчилгээний хэрэглэгч нийлээд 100 сая давсан байна.

Doordarshan ТВ-ээс олон нийтэд эфирээ хүргэх олон янзын арга хэрэглэдэг. Үүний нэг нь DD Free Dish байдаг. Нэг удаа set-top-box худалдаж аваад хязгааргүй хэрэглэдэг үйлчилгээ байна. Одоогоор 50 сая өрх энэ үйлчилгээг авч байна. Энэ том газар нутагтай, олон хүнтэй газарт аль болох олон аргаар л хүндээ хүрэхийг эрмэлзэж байгаа ажээ.

ТВ болон ОСДҮЭ хоорондын техник холболтын асуудлаар сайн мэдээлэл байхгүй ч сувгийн дугаарлалтын асуудал дээр ТВ-үүд ОСДҮЭ-д мөнгө төлөх тохиолдол байдаг болохыг судалгаанд оролцогч хэлж байв.

Европын орнууд

Зах зээл дээрх мөнгөний хэмжээ том. Харьцангуй бага газар нутагтай. Хөгжил өндөр. Must-carry суваг нь үндсэн концепттой бөгөөд Европын Холбооноос гаргасан Universal Services Directive-д тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл бидний судалж буй асуудлыг Европын Холбоонд логик гаргалгаатайгаар шийдэхийг оролдсон. Universal Services Directive болон түүний хэрэгжилтийн асуудлыг судлах нь Европын Холбооны улсуудыг хамрахаас гадна манай асуудлуудыг олон талаас нь харах боломж олгож байгаа юм.

Universal Services Directive

Энэ зааварчилгаа нь 2002 онд Европарламенттаас харилцаа холбооны цахим сүлжээ, үйлчилгээний нийтлэг үйлчилгээ, хэрэглэгчийн эрхийн асуудлыг хамран батлагдсан. Тус зааварчилгааны 31-р зүйлд 'Must carry' статусын тухай дэлгэрэнгүй зааж өгсөн байна.

Тус зааварчилгаагаар must carry үүрэг нь зөвхөн нөлөө бүхий олон хэрэглэгчтэй (significant number of end-users) ОСДҮЭ-д үйлчлэх, нөгөө талд тодорхой заасан Ерөнхий Сонирхлын (General Interest) телевизүүдэд үйлчилнэ гэж заасан байдаг. Үүнтэй холбоотойгоор, голдуу төлбөр мөнгөний асуудалтай холбоотойгоор шүүхийн маргаанууд хэд хэд үүсэж байжээ.

Ер нь must-carry гэдэг асуудал кабелийн үйлчилгээтэй холбогдож үүссэн түүхтэй. Харин Кипр, Грек, Итали зэрэг кабелийн үйлчилгээ өндөр хөгжөөгүй газруудад бол энэ асуудал нэг их гараагүй. Өөрөөр хэлбэл Грек, Кипр, Люксембург, Итали улсуудад must-carry гэдэг дүрэм хэрэгжээгүй. Хорват, Грек улсуудад заавал дамжуулах сувгийн шаардлага гэж байгаа ч түүнд нь нийцсэн суваг байхгүй байна.

Европын холбооны хувьд must-carry сувгийн үзэл баримтлалыг тодорхойлохдоо бизнесийн хүчин зүйлсийг авч үзсэн. Хэрэв ОСДҮЭ (cable, DTT, satellite, IPTV зэрэг харилцаа холбооны сүлжээг нийлүүлэгч) тодорхой сувгуудыг заавал дамжуулах үүрэг хэрэгжүүлэх нь тодорхой зардал, чирэгдэл үүсгэнэ. Нөгөө талаас заавал дамжуулагдах ёстой учраас ОСДҮЭ-д контентоо

заавал хүргэх ёстой, үүнтэй холбоотой үүсэх зардлыг бродкастэр өөрөө хариуцах ёстой гэж үзвэл мөн л зардал, хүндрэл үүснэ.

Ерөнхийдөө must-carry статусын хувьд бродкастэр нь хөтөлбөр нийлүүлсний төлбөр гэж авахгүй, ОСДҮЭ нь заавал дамжуулсны хариуд төлбөр авахгүй гэсэн зохицуулалт үйлчилж байна.

Гэхдээ оюуны өмчийн асуудал бусад хуулинд мөн хамаардаг учир улс улсын онцлог өөр болж байна. Германд бродкастэр тал оюуны өмчийн төлбөр гэж авдаг, нөгөө талд ОСДҮЭ нь дамжуулалтын хөлс гэж авдаг бол Латвид оюуны өмчийн асуудал must-carry статустай тохиолдолд үйлчлэхгүй заасан байна.

Ер нь must-carry зохицуулалтанд зардлын асуудлыг тусгаагүй тохиолдлууд олон. Австрид ОСДҮЭ нь “эдийн засгийн хувьд ноцтой хүндрэл гарахгүй тохиолдолд” ORF-г дамжуулна гэж заасан. Мөн шаардлагатай төлбөрийн хэмжээг KommAustria тодорхойлж өгнө гэсэн.

Германд ОСДҮЭ-ид хөтөлбөр дамжуулсны төлөө төлбөр авдаг байжээ. Олон нийтийн телевизүүд нь дамжуулалтын төлбөрөө төлөх, төлөхгүй эсэх нь мөн л маргаан дагуулсан асуудал. Ингээд 2012 онд ARD, ZDF хоёр ТВ сувгуудын дамжуулалтын төлбөр төлж байх гэрээгээ 2012 онд цуцлахад Kabel Deutschland, Unitymedia нар төлбөр авна гэж шүүхдсэн боловч амжилт олоогүй.

Эстонид мөн ижил асуудал үүсэж байсан байна. Эрх зүйн үндэслэлийн хувьд 2013 онд “FTA телевизүүд кабелийн операторуудад төлөх дамжуулалтын төлбөр боломжийн (бага) байхыг шаардах эрхтэй” гэж нэмэлт оруулсан байдаг. Гэхдээ энэ төлбөрийг хэрхэн тооцох талаар нарийвчлан тусгаагүй болохоор арилжааны бродкастэрууд болон ОСДҮЭ-ийн хоорондын хэр их төлбөр төлөгдөх ёстой тухай асуудлыг тодорхой болгож чадаагүй юм.

Францын хувьд IPTV болон кабелийн операторууд дотоодын олон нийтийн сувгуудыг үнэ төлбөргүй дамжуулах ёстой гэсэн шаардлага нь үндсэн хуулийн цэц дээр очсон. 2016 оны 3-р сард Францын Үндсэн Хуулийн Цэцээс энэ шаардлага нь Үндсэн хуульд нийцэж байна гэж шийдвэрлэжээ. Гэхдээ шүүхээс зардлын хувьд “энэхүү шаардлага нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрийг тээвэрлэж, хэрэглэгчид хүргэх тухайд хамаарахаас бус түүнтэй холбогдон үүсэх холболтын болон барилгын ажилд хамаарахгүй. Мөн хөтөлбөрийг дижитал хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой зардал нь заавал дамжуулах үүрэгт хамаарахгүй” гэж шийдвэрлэсэн байна.

Их Британи

Монгол дахь нөхцөл байдлыг тайлбарлахад “ийм юм болж байсан” гэсэн ганц тохиолдол нь Их Британи байлаа. Их Британийн хувьд Virgin Media-ийн үед ийм асуудал үүсч байсан байна.

Их Британи нь бродкастинг гэдэг зүйл үүссэн, өөрсдөө томоохон үйлдвэрлэгч улс. Зурагтаа ч хийдэг. Ихэнх улсуудад бродкастинг дөнгөж эхэлж байхад бараг

99.9% terrestrial сүлжээ татсан, тэрэн дээрээ multiplex гэдэг аргаар олон суваг дамжуулаад эхэлсэн байсан.

Virgin media анх байгуулагдахад “өрх бүрийг дайрч өнгөрнө” гэсэн уриатайгаар ирсэн. Нээрээ л өрх бүрийг “дайраад өнгөрсөн” гэжээ. Өөрөөр хэлбэл аналог кабелийн үйлчилгээ анх нэвтрэхэд энэ нь UK зах зээл дээр явцгүй гэж харж байсан, тийм л байсан. Virgin media нь Telewest, NTL гэдэг хоёр том компани нэгдэж байгуулагдсан, тэр хоёр том компанийн мөнгийг кабелийн үйлчилгээ нэвтрүүлэхэд зарцуулсан. Үнэхээр том компани тулдаа тэр буруу стратегийг даваад гарсан.

Интернэт гарч ирснээрээ кабелийн үйлчилгээ үндсэндээ явцгүй болсон ч Virgin media компанийг аварсан. Одоо бол Freeview гэдэг концепт руу шилжиж байна. Freeview гэдэг нь DTT үйлчилгээ. Digital UK гэдэг компани ажиллуулдаг. Энэ компанийг BBC, ITV, Channel 4, Channel 5 хамтран эзэмшдэг.

Мальта

Мальта улс нь 500,000 орчим хүнтэй. Газар нутгийн хувьд Монгол улсын нэг аймгийн төвийн нутагтай тэнцэнэ. Иймээс жижигсгэсэн Улаанбаатар гэж үзэж болно. Харьцангуй жижиг улс бөгөөд зах зээл нь харьцангуй цэгцтэй зохион байгуулагджээ. Мальта улсын жишээ нь Европын Холбооны Universal Services Directive нэг улс дээр хэрхэн хэрэгжсэний маш энгийн бөгөөд ойлгомжтой жишээ юм.

Мальта улсад үндсэн гурван байгууллага ОСДҮЭ-ийн статустай ажилладаг. Эдгээр нь Public Broadcasting Services Limited төрийн өмчит компанийн ажиллуулдаг DTT сүлжээ, Melita компанийн ажиллуулдаг digital cable, GO компанийн ажиллуулдаг IPTV+DTT сүлжээ. Melita зах зээлийн 60%-г эзэлдэг бол GO нь зах зээлийн 40%-ийг эзэлнэ.

Мальта улсад 10 орчим дотоодын ТВ суваг (local TV channel) бий. Эдгээрт must-carry статус өгөх эсэхийг MCA шийдэж байна. Үүний үндсэн шалгуур нь Ерөнхий Сонирхлын буюу General Interest хөтөлбөр гаргадаг байх гэж шалгуур. Өөрөөр хэлбэл арилжааны хувьд ашигтай байх чиглэлд анхаарах нь олон нийтийн, үндэсний гэсэн зарим агуулгыг орхигдуулах эрсдэлтэй гэсэн үндэслэл, логик дээр тулгуурладаг. Энэ статусаа 3 жил тутам үнэлж байхаар тогтсон байна.

Нөгөө талд must-carry статусыг хэрэгжүүлэх ёстой кабелийн операторуудад шалгуур тогтоосон. Өөрөөр хэлбэл бүх кабелийн оператор must-carry статусыг мөрдөх шаардлагагүй юм. Үүнд нөлөө бүхий олон хэрэглэгчтэй (significant number of end-users) бол must-carry статусыг хэрэгжүүлнэ гэж заасан. Энэ шалтгаанаар 2013 онд аналог кабелийг must-carry хэрэгжүүлэх чөлөөлсөн байна. Мөн энэ шалтгаанаар буюу нөлөө бүхий олон хэрэглэгчтэй биш гэсэн шалтгаанаар ОТТ үйлчилгээ одоогоор must-carry шаардлагад хамаарахгүй байна.

Эдгээр асуудлын хүрээнд must-carry статусыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ТВ болон ОСДҮЭ нар нэг нэгэндээ төлбөр төлөх эсэх асуудлыг эргэн харж,

кабелийн операторууд нь эцсийн хэрэглэгчээс төлбөр авдаг, must-carry суваг байршуулснаар техникийн ачааллын хувьд асуудал гарахгүйн дээр олон суваг санал болгох тусам бизнес утгаараа сайн учир must-carry хэрэгжүүлснийхээ төлөө төлбөр авах шаардлагагүй. ТВ-үүд нь зөвхөн арилжааны чиглэлийг барихаасаа илүү Ерөнхий Сонирхлын гэсэн чиг үүргийг хүлээж байгаа учир төлбөр төлдөг ч, авдаг ч байх нь зохимжгүй гэж дүгнэсэн.

Мальта улсын хувьд зөвхөн кабелийн сувгаар гардаг сувгууд байдаг. Гэхдээ тус сувгуудыг Melita, GO гэдэг хоёр кабелийн оператор өөрсдөө ажиллуулдаг. Үүний хүрээнд Melita-ийн сувгууд зөвхөн Melita-аар, GO-ийн сувгууд зөвхөн GO-өөр гардаг байна.

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-д бродкастэр болон кабелийн операторын харилцаа үндсэндээ 1934 оны Харилцаа Холбооны тухай хууль, түүний 1984, 1992, 1996 оны нэмэлт өөрчлөлтөөр зохицуулагдаж байна. Үүний хүрээнд FCC хяналт тавьж ажилладаг.

АНУ нь муж улсуудаас бүрддэг, муж улсууд тус бүр өөрсдийн гэсэн зохицуулалт, хуультай байдаг. Тиймээс Холбооны хэмжээнд логигоор ерөнхий концепт, логигоор зохицуулах оролдлого хийсэн нь харагддаг. Энэхүү логигоор манайд үүсээд буй асуудалд хандах нь зарим асуудлыг шинээр харах давуу тал олгож байна.

Кабелийн оператор үйл ажиллагаа эрхлэхдээ аль зах зээл дээр ажиллахаа тодорхойлно. АНУ нь газар нутаг, суурьшил, тэдгээрийн хүн амын ТВ үзэлтийн онцлогоос хамаараад Designated Market Area буюу зах зээлийн бүсчлэлд хуваасан байна. Улмаар ОСДҮЭ зөвшөөрлийг тухайн бүст буюу зах зээл дээр ажиллах эрх маягаар олгоно. Энэ нь бродкастэруудын тухайн бүс нутагт дамжуулах эрхтэй харилцан уялдана. Үүний тодорхойлолтонд АНУ-ын телевиз үзэлтийн судалгааны компани болох Nielsen оролцдог.

Кабелийн үйл ажиллагааг муж бүрт өөр өөрөөр зохицуулсан байдаг. Массачусетс мужийн хувьд кабелийн үйл ажиллагааны зохицуулалтыг хариуцахаар байгуулагдсан мужийн хороо, зөвлөл ажилладаг. Аляска, Коннектикут, Делавэйр, Нью Жерси зэрэг мужуудын хувьд эрх бүхий байгууллага нь дэд бүтцийн олон нийтийн зөвлөл гэдэг илүү өргөн асуудал хариуцсан байгууллага байна. Хавай мужид бол кабелийн операторын зохицуулалтын асуудал нь Худалдаа, Хэрэглэгчийн Асуудал эрхэлсэн яам байна. Үүнээс гадна хотын кабелийн хороо, хотын иргэдийн хурал гэх мэт байгууллагууд шууд хариуцаж байдаг. Эдгээрийг нийтэд нь “дотоодын франчайз олгох газар” гэж хуулинд тодорхойлсон.

Харилцаа холбооны тухай хуулиар (Холбооны хэмжээнд) кабелийн оператор нь франчайзгүйгээр, өөрөөр хэлбэл “дотоодын франчайз олгох газар”-аас зөвшөөрөл авахгүйгээр үйл ажиллагаа явуулж болохгүйг заасан. Дотоодын франчайз олгох газар нь эрх мэдлийнхээ хүрээнд франчайз буюу тусгай

зөвшөөрөл олгох боловч онцгой эрх олгохгүй, мөн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шалтгаангүйгээр гацаахгүй зэрэг заалтыг хуулиар зохицуулсан байна.

1992 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр телевиз болон ОСДҮЭ-ийн хооронд хамтын ажиллагааны зарчмыг суулгаж өгсөн. Үүний хүрээнд дотоодын арилжааны бродкастэр болгон “must-carry” болон “дамжуулах зөвшөөрөл” гэсэн хоёр нөхцлөөс сонгож, тухайн нэг зах зээл дээр ажиллаж байгаа ОСДҮЭ-дэд санал болгох ёстой.

Must-carry/Дамжуулах зөвшөөрлийн нөхцлийн сонголтыг 3 жил тутам хийнэ. Анхны сонголт 1993 оны 6-р сарын 17-нд болсон. Эндээс 3 жил тутам явагдсаар сүүлийн сонголтын хэрэгжилт 2024 оны 1 сарын 1-ээс эхэлсэн байна.

Must-carry: Хэрэв дотоодын арилжааны телевиз must-carry статусыг сонговол тус зах зээл дээр байгаа ОСДҮЭ-ээр бүгдээр нь гарах эрхтэй гэж ойлгож болно. 12 сувгаас олон суваг дамжуулдаг ОСДҮЭ бүр хүчин чадлынхаа 1/3-г must-carry нөхцөлд зориулах ёстой гэдгийг хуулиар заасан. Жишээ нь хэрэв кабелийн систем 60 суваг гардаг бол 20 суваг нь заавал must-carry байх ёстой. Хэрэв тухай зах зээл дээр 25 суваг must-carry нөхцлийг сонгосон бол ОСДҮЭ өөрөө мэдэн 20-ийг нь сонгож болно. Хэрэв 15 суваг must-carry нөхцөл сонгосон бол 15-ууланг нь дамжуулах үүрэгт болно гэсэн үг. Must-carry нөхцлөөр явж байгаа суваг нь өөрийн сувгийн дугаарлалтыг ОСДҮЭ-ээс шаардах эрхтэй байдаг.

Эндээс үзэхэд must-carry нөхцөл нь тодорхой хэмжээний давуу эрх эдлэх мөртлөө эргээд заавал дамжуулагдана гэсэн үг биш болж байна.

Дамжуулах зөвшөөрөл: ОСДҮЭ нь телевизийн сувгийг ямар нэгэн дамжуулах зөвшөөрөлгүйгээр дамжуулах хориотой. Must-carry нөхцөл сонгосон телевиз нь энэ дамжуулах зөвшөөрлөө нээлттэй өгсөн гэсэн үг гэж ойлгогдоно. Тиймээс “дамжуулах зөвшөөрөл” нөхцлийг сонгосон тохиолдолд кабелийн оператор тус сувгийг дамжуулъя гэвэл ямар нэг байдлаар зөвшөөрлийг нь авах ёстой. Телевиз болон ОСДҮЭ-ийн хоорондын тохиролцоо нь цэвэр талуудын хоорондын асуудал бөгөөд шаардлагатай тохиолдолд ямар нэг төрлийн төлбөр хийгдэнэ. Энэ нь мөнгөн төлбөр, нэмэлт суваг гаргах эрх, ТВ-ийн талаас бол зар сурталчилгааны цаг гэх мэт байж болно.

Дамжуулах зөвшөөрлийн гэрээний нөхцлийг дээр дурдсаны адил 3 жил тутам шинэчилнэ. 3 жилийн хугацаа дуусахаас өмнө дараагийн нөхцлөө шинэчилж чадвал ОСДҮЭ-ээр тухайн суваг саадгүй үргэлжлэн гарна. Харин тухайн хугацаанд харилцан тохиролцож шийдвэрт хүрж чадаагүй бол ОСДҮЭ нь тухай сувгийг гарахыг зогсоох ёстой.

Үүний хүрээнд FCC-ээс ийм шалтгаанаар ОСДҮЭ-ийн хэрэглэгч аливаа сувгийг үзэх боломжгүй болсон бол хэрхэн хүлээн авч үзэх вэ гэдэг тал дээр зөвлөмж гаргасан байна. Үүндээ 3 боломжийг дурдсан нь:

- Агаарын давтамжийн хүлээн авагч ашиглан бусад бродкасттай хамт хүлээн авч үзэх. Үүний тулд Digital TV, эсвэл конвертортой байх хэрэгтэй.
- Тус суваг гарч байгаа өөр ОСДҮЭ ашиглах (Тэгэхдээ тус суваг нь өөр ОСДҮЭ-ийн үйлчилгээнд мөн байгаа эсэхийг нягталж үзэх)
- Интернэтээр дамжуулж байгаа эсэхийг шалгаж үзэх гэсэн байна.

Энэ нь эргээд бидний эрэлхийлж буй зааглах цэгийн асуудал АНУ-ын хувьд ямар байдлаар шийдэгдсэн бэ гэдэгт хөтөлж байна.


FCC-ээс үндсэндээ гурван төрлийн лиценз олгодог. Ингэхдээ 8 жилийн хугацаагаар олгоно. Нөхцөл шаардлагаа хангаж ажилласан бол сунгадаг. Лиценз эзэмшигч нь агаарын долгион ашиглаж байгаагийн хувьд лицензийн нөхцөл шаардлагын дагуу ашиглаж байгаа тухайгаа тайланг улирал тутам олон нийтэд танилцуулж байх үүрэгтэй.

Commercial station: Арилжааны телевизийн станц буюу зар сурталчилгааны орлогод суурилан үйл ажиллагаа явуулдаг этгээд.

Non-commercial educational station: Сонсогч, үзэгчдийн хандив, захиргааны санхүүжилт зэргээр үйл ажиллагааны зардлаа нөхдөг газар. Үүнээс гадна ашгийн төлөө байгууллагаас хандив авч болох бөгөөд түүнийгээ зохистой байдлаар зарлан, сурталчилж болно гэж заасан.

Low-power television station: Тодорхой хүрээлэл буюу community-д үйлчлэл зорилготой бага зардлаар босдог, үйл ажиллагааны зохицуулалтын хувьд харьцангуй уян хатан.

Харин дотоодын ТВ-ийг ОСДҮЭ хүлээн авч дамжуулах холболтын схемийн бүдүүвч зургийг дараах байдлаар зурсан байна.



Өөрөөр хэлбэл АНУ-ын хувьд Телевиз (TV station) гэдэг нь хөтөлбөр бэлтгэхээс гадна түүнийгээ агаарын давтамж ашиглаж цацдаг, тэр нь тусгай зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг байдаг ажээ. Иймээс зааглах цэг, техник холболтын асуудал телевиз, ОСДҮЭ хоёрын хооронд үүсэх үндэсгүй. Энэ хоёр этгээдийн хооронд зөвхөн сигналын чанарын асуудал яригддаг байна.

4. Тохиромжтой туршлага

Дээр дурдсан олон улсын кэйсүүдээс бидний үндсэн асуудалтай холбоотой асуудлуудтай холбоотой туршлага, тэдгээрийн контекстийг тодорхойлж, тохиромжтой хувилбаруудыг илрүүлэх гэж оролдов.

1. Must-carry статусын үзэл санаа

Ази номхон далайн орнууд

Ази номхон далайн орнуудад must-carry гэдэг ойлголт нь нарийвчлан зохицуулагдаагүй, өөрөөр хэлбэл үзэл санааны түвшинд хэлбэржих түвшинд хүрээгүй байна гэж ойлгож байна. Голдуу төрийн телевиз нь must carry байдаг гэсэн хариулт өгж байлаа.

Must-carry нөхцөл де факто үйлчилж байгаа зарим орнууд байна. Жишээ нь Индонези улсад улс даяар цацагдаж байгаа хувийн 13 суваг мөн must-carry сувагт тооцогддог. Энэ нь газар зүйн онцлогоос хамаараад контент үйлдвэрлэгч талд хүч нь төвлөрсөн, ТВ ажиллуулдаг компаниуд нь кабелийн оператор хийдэг зэрэг сонирхолтой шинж чанаруудтай холбоотой. Ер нь must-carry нөхцөл тодорхойлогддог үзэл санаа нь бүрэн хөгжөөгүй, уламжлалт ойлголт дээр түшиглэсэн мэт байгаа нь Монголын кэйстэй төстэй байна.

Европын Холбооны орнууд ба Их Британи

Европын Холбооны хувьд Европарламентаас Universal Service Directive баталсан. Энэ нь ЕХ-нд багтах улсуудын хувьд мөрдөх ерөнхий логик гаргалгааг гаргаж өгснөөрөө онцлогтой. Өөрөөр хэлбэл must-carry үзэл санааг тодорхойлох гэж оролдсон нь манай судалгаа, түүнээс гарах шийдэлд илүү хэрэг болох боломжтой. Үүнд:

